



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/255

Улаанбаатар хот


Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 388, 2019 оны 46 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/149 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжих Сонгинохайрхан дүүрэгт баригдах боловсролын салбарын зарим барилга, байгууламжийн жагсаалтыг хавсралт ёсоор баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Ж.Сандагсүрэнд шилжүүлэн, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээний санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар /Б.Мөнхбат/-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар /Ч.Однасан/-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

  
С.АМАРСАЙХАН

111020001??0

Нийслэлийн Засаг даргын 2019 оны

04 сарын 02 ны өдрийн  
 А/255 дугаар захирамжийн  
 хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2019 ОНД САНХҮҮЖИХ  
 СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ БАРИГДАХ БОЛОВСРОЛЫН  
 САЛБАРЫН ЗАРИМ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН  
 ЖАГСААЛТ

/сая төг/

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2019 онд санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
1	XII.1.1.32	Сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 31 дүгээр хороо/	2018	2019	4,000.0	1,204.0
2	XII.1.1.41	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар хороо/	2018	2020	5,566.0	2,500.0
3	XII.1.1.77	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр хороо/	2018	2020	6,166.6	2,600.0
4	XII.1.1.93	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 10 дугаар хороо/	2018	2019	1,500.0	800.0
ДҮН					17,232.6	7,104.0